



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/561

Алтай хот

Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1 дэх заалт, "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн 3 дугаар зүйлийн 3.6.8 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол, Засаг даргын зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 18-ны 39 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн хүрээнд бага насны хүүхдийн хөгжил, төлөвшилд чиглэсэн сургалт, цахим контент бүхий нөлөөллийн "Дэлгэцийн донтолт-бодит аюул" аяныг зохион байгуулах "Эерэг өөрчлөлтийн түүчээ" төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Нийгмийн бодлогын хэлтэс (Л.Отгончимэг)-т олгосугай.

2. Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, удирдамж, хөтөлбөр зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Л.Отгончимэг)-т үүрэг болгосугай.

3. Төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах 18,180,000 (арван найман сая нэг зуун наян мянга) төгрөгийг "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн батлагдсан зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

4. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

C:/My documents/-3A-4 doc

0201301935